



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/659

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үенч сумын Соёлын өдрийг тохиолдуулан ардын болон сонгодог урлагийг орон нутгийн иргэдэд хүргэх, олон угсаатны өв, соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн авъяас чадвараа дайчлан ажиллаж буй Үенч сумын Цэцэрлэгийн дуу хөгжмийн багш, ардын авъяастан Н.Гангармядаг, Соёлын төвийн Өв соёлын ажилтан Б.Цогзолмаа нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Н.Гангармядаг, Б.Цогзолмаа нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Үенч сумын дээр байгууллагуудын эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/659 Ch

02 03262